



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Хужирт сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2024 оны цэргийн тоо бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 05-наас 01 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл биечлэн болон цахим хэлбэрээр явуулсугай.
2. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг 1 дүгээр, тоо бүртгэл явуулах байр, хүлээлгэн өгөх хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Багийн Засаг дарга нарт даалгах нь:
 - 3.1. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг заасан хугацаанд чанартай явуулах;
 - 3.2. Хуваарийн дагуу тоо бүртгэлийн материалыг хүлээлгэн өгөх;
4. Цэргийн тоо бүртгэлийг заасан хугацаанд чанартай зохион байгуулан аймгийн Цэргийн штабт 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (З.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.
5. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлтэй холбоотой гарах зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. БАТБАЯР

622401002

D:Alban bichig;Zahiramj 2023